



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 170

Улаанбаатар хот

**ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Зөвшөөрлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 362 дугаар тогтоолын 5 дахь заалтын ", байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх" гэснийг хассугай.

2.Байнгын ачаа тээврийн хил нэвтрэх "С" төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжтэй байгуулсан тээвэрлэлтийн гэрээг үндэслэн, улс хоорондын ачаа тээвэрлэлтэд тавигдах шаардлагуудыг хангасан тээвэрлэгчид олгох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн сайн д.Б.Дэлгэрсай ханд даалгасугай .

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН